

Dornogobi2010Re1

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН, ДҮГНЭЛТ

2011 оны 03 дугаар сарын 14- ны өдөр

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан „Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам,-ын дагуу Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуяг, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, тайлагнаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 06 дугаар хуралдаанаараа хэлэлцээд, 06/04 дүгээр тогтоол гаргаж, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнг “хангалттай” гэж үнэлсэн болно. /Тогтоолын хуулбарыг хавсаргав/

“Тогтоол хэрэгжүүлэх асуудлаар чиглэл өгөх тухай” Монгол улсын Засгийн газрын 2010 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн ХЭГ/135 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тайлангийн багцад дараахь мэдээллүүдийг багтаасан болно.

<input type="checkbox"/>	Үүсгэсэн файлын нэр	Мэдээллийн нэр
1	dornogobi2010Re1	Дорноговь аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн, дүгнэлт
2	dornogobi2010Re2	Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт
3	dornogobi2010Re3	Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
4	dornogobi2010Re4	Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр болон гадаад дотоодын өрөнгө оруулалттай төслүүдийн хэрэгжилт
5	dornogobi2010Re5	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
6	dornogobi2010Re6	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн тайлан
7	dornogobi2010Re7	Аймгийн Засаг даргаас Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлт
8	dornogobi2010Re8	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны <input type="checkbox"/> Шинэ Дорноговь <input type="checkbox"/> хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт
9	dornogobi2010Re9	Аймгийн Засаг даргаас эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/ нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

10	dornogobi2010Re10	Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт
11	dornogobi2010Re11	Үйл ажиллагааны ил тод байдлын тухай мэдээлэл
12	dornogobi2010Re12	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн үнэлгээ
13	dornogobi2010Re13	Хэрэглэгчийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралтын дагуу аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны үнэлгээг дараахь байдлаар гаргав.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

□	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1.	Бодлогын зорилтын үр дүнгийн үнэлгээ	1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	83,7	4,18
		2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	56,8	2,84
		3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	87,9	4,39
Үнэлгээний дундаж оноо			76,1	3,80
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	89,5	4,47
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	88,4	4,42
		3. Монгол улсын ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100,0	5,0
		4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	48,4	2,42
Үнэлгээний дундаж оноо			81,5	4,07
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	90,2	4,51
		2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	88,3	4,41

Үнэлгээний дундаж оноо			89,2	4,46
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100,0	5,0
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100,0	5,0
		3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	100,0	5,0
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал	100,0	5,0
Үнэлгээний дундаж оноо			100,0	5,0
5	Үйл ажиллагааны үр дагаварын үнэлгээ	1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	93,0	4,65
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	42,7	2,13
Үнэлгээний дундаж оноо			67,8	3,39
Ерөнхий үнэлгээ			82,9	4,14

Үнэлгээний талаархи зарим тайлбар:

1. Аймгийн Засаг даргынүйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг үнэлэхдээ Монгол улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газраас 2010 оны 10 дугаар сард тус аймагт хийсэн шалгалтын багааөгсөн зөвлөмжийг үндэслэн, бүрэн эрхийн өнгөрч байгаа хугацаанд нийт зорилтын мөн тийм хэмжээний хувийг хэрэгжүүлсэн байх учиртай гэсэн ерөнхий зарчмыг баримтлан үнэлгээ өгсөн болно.

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зорилт тус бүрийн хэрэгжилтэнд хувь тавьж үнэлгээ өгөхдөө тайлант хугацаанд бүрэн хэрэгжсэн байх, үлдэж байгаа хугацаанд дахин авч үзэхгүй зорилтын хэрэгжилтийг 100 хүртэл хувь, үргэлжлэн хэрэгжих зорилтыг 50 хүртэл хувь, хэрэгжиж эхлээгүй буюу хугацаа болоогүй зорилтыг ажлын эхлэл, явцыг харгалзан 0,0-30,0 хүртэл хувийн үнэлгээ өглөө. Ийнхүү өгсөн үнэлгээгээр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт 48,4 хувийн гүйцэтгэлтэй байна гэсэн дүн гарсан болно. Энэ нь эхний хоёр жилд хэрэгжүүлэх зорилтыг 100,0 хувь гэж үзвэл Засаг дарга зорилтоо $48,4 \times 2 = 96,8$ хувиар биелүүлээд байгаа гэсэн үг болно.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР